



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 51-263051, Факс: (976) 7004-3479
E-mail: info@energy.gov.mn

2021. 10. 13 № а/3647
танай 2021. 10. 04 -ны № 38 -т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Эрхэм Улсын Их Хурлын гишүүн танд энэ өдрийн мэнд хүргэе.

Танаас ирүүлсэн асуултад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. “Таван толгой түлш” ХХК нь 2020-2021 оны өвлийн оргил ачааллын үед хоногт 3,500-4,300 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн хэрэглэгчдэд нийлүүлж ажилласан бөгөөд 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд үйлдвэрийн их засварын ажлыг гүйцэтгэн 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс шугамуудыг үе шаттайгаар ажиллагаанд оруулж сайжруулсан шахмал түлш нөөцлөх ажлыг эхлүүлсэн.

Сайжруулсан шахмал түлшний борлуулалт эхэлсэн өдөр буюу 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлш 69,851 тонн буюу 29 хоногийн (өвлийн оргил ачааллын 19 хоног) нөөц, барьцалдуулагч 682 тонн буюу 10 хоногийн нөөц бүрдүүлсэн.

2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар сайжруулсан шахмал түлшний нөөц 64,273 тонн, барьцалдуулагчийн нөөц 2,071 тонн байна.

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, нөөц бүрдүүлэх ажилд доголдол үүсээгүй бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр борлуулалтын 40 цэг, 10 дугаар сарын 3-ны өдөр 128 цэг ажиллаж байсан нь иргэдийг сайжруулсан шахмал түлш худалдан авахад очер, дараалал ихэссэн шалтгаан болсон байна.

“Таван толгой түлш” ХХК-иас асуудлыг шийдвэрлэхээр борлуулалтын цэгийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэн 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 500 цэгээр иргэдэд сайжруулсан шахмал түлш борлуулж байна.

2. 2020-2021 оны халаалтын улиралд гэр хорооллын 171,482 айл өрхөд нийт 572,175 тонн сайжруулсан шахмал түлш борлуулсан нь нэг өрх дунджаар 3.3 тонн түлш хэрэглэсэн тооцоо гарч байна.

“Таван толгой түлш” ХХК нь 2021-2022 оны халаалтын улиралд 582,900 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн нийслэлийн түүхий нүүрс хориглосон бүсийн 171,482 өрхөд нийлүүлэхээр төлөвлөсөн нь нэг өрхөд дунджаар 3.4 тонн түлш ноогдох бөгөөд энэ хугацаанд 300 орчим өрхийн дунд 1 борлуулалтын цэг буюу нийт 600 цэг ажиллуулахаар төлөвлөсөн.

Цаашид нөөцийг тогтмол хэмжээнд барих, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор баруун бүсийн үйлдвэрт бутлуурын байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, зүүн бүсийн үйлдвэрт хатаах байгууламж, 25 кг-ын шуудайнд савлах тоног төхөөрөмж угсарч ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

170602266